

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН

**“ХҮН БОЛОХ БАГААСАА” ХҮҮХДИЙН АВЬЯАС СУРГАЛТЫН ТӨСЛИЙН  
ТЕЛЕ БОЛОН ЦАХИМ ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

**Ерөнхий мэдээлэл:**

“Хүн болох багаасаа” хүүхдийн авьяас сургалтын төсөл нь Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/19 дүгээр тогтоолоор батлагдсан.

“Хүн болох багаасаа” хүүхдийн авьяас сургалтын төслийн зорилго нь Дорнод аймгийн хүүхдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, сонирхолд нь тулгуурлан хөгжүүлэх, сурах арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх замаар өв уламжлалаас суралцсан, гоо зүйн мэдрэмжтэй, урлагийн боловсролтой, шинжлэх ухаанч, техник сэтгэлгээтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх.

**Хамрах хүрээ:** Аймгийн төв болон хөдөөгийн 13 сумын нийт хүүхэд, багачууд, гэр бүлд.

**Санхүүжилт:**

“Хүн болох багаасаа” хүүхдийн авьяас сургалтын төслийн зардлаас 15,0 сая төгрөг /орон нутгийн хөгжлийн сан/


**Теле болон цахим хичээл сургалт зохион байгуулах ерөнхий шаардлага:**


1.	“Хүн болох багаасаа” хүүхдийн авьяас сургалтын төслийн теле болон цахим сургалтын нэр төрөл: 1. Математик, шинжлэх ухаан 2. Зохион бүтээх, техник технологи 3. Оюун ухаан, ой тогтоолт 4. Утга зохиол 5. Уран зураг 6. Дуу хөгжим 7. Бүжиг 8. Хувь хүний хөгжил <i>Лендерт оролцогч нь “Хүн болох багаасаа” хүүхдийн авьяас сургалтын төслийн теле болон цахим хичээл сургалтыг дээрх төрлүүдээр зохион байгуулна/</i>
2.	Теле болон цахим хичээлийг “Хүн болох багаасаа” төслийн хүүхдийн авьяас хөгжүүлэхээр захиалагчтай гэрээ байгуулсан талуудтай хамтран зохион байгуулна.
3.	Теле болон цахим хичээл үзсэн хүүхдүүд, багш, эцэг эхчүүдээс сургалтын явц, үр дүнгийн талаарх санал хүснэгтийг нээлттэй хүлээн авч, эргэх холбоотой хамтран ажиллана.
4.	Теле болон цахим хичээлийг олон нийтэд хэвлэл, мэдээлэл, facebook page болон цахим хуудсаар танилцуулж, түгээн дэлгэрүүлсэн байх.
5.	Теле болон цахим хичээл, контент, мэдээлэлд Дорнод аймгийн лого, төслийн нэр, таних тэмдгийг байршуулсан байх

6.	Зохиогчийн оюуны өмчийн эрх нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу байх
7.	Теле болон цахим хичээл, бусад мэдээллийг DVD болон эх файлаар захиалагч талд хүлээлгэн өгөх

**Тендэрт оролцогчдод тавигдах шаардлага:**

1.	Тендэрт оролцох албан хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.	<b>Байгууллагын танилцуулга:</b> Үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга
3.	<b>Ажлын туршлага:</b> Теле болон цахим сургалт зохион байгуулж байсан туршлага, амжилтын түүх, хамтран ажилласан байгууллагын мэдээлэл
4.	<b>Хүний нөөцийн мэдээлэл:</b> Мэргэжлийн боловсон хүчин танилцуулга /сэтгүүлч, зураглаач, техникийн ажилтан зэрэг/
5.	<b>Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүчин чадал:</b> Теле болон цахим сургалтыг дамжуулах TV суваг, цахим хуудас, facebook page, дүрс, бичлэгийн студи, тоног төхөөрөмж
6.	<b>Төсвийн дэлгэрэнгүй танилцуулга:</b> Теле болон цахим сургалт зохион байгуулах нийт төсвийн дэлгэрэнгүй задаргаа.

ХЯНАСАН  
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА  Э.ЭРДЭНЭБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН  
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨРЖИЛ ХАМГААЛЛЫН  
ГАЗРЫН ДАРГА  Э.ЖАВХЛАН

